

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М. Батсуурь
Улаанбаатар хот	Утас: 70453317 Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер: М. Бат-Амгалан Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
	Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Ариун төгс оршихуй Аудит" ХХК-ийн аудитор: С. Эрдэнэчимэг
	Утас: 9902-3656 Цахим хаяг: ariuntugsorshihuaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЭГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН 7-Р  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
З.УУГАНБАЯР ТАНАА

2023.02.24 № УВА-2023/112/НА-СНА-ТШЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700191

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>93,221,500.50</u></b>	<b><u>91,307,718.00</u></b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	9,201,563.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	9,201,563.00
3121	Төгрөг	00.00	9,201,563.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	9,201,563.00
33	АВЛАГА	14,000,000.00	00.00
335	Бусад авлага	14,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	14,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,221,500.50	82,106,155.00
351	Түүхий эд материал	00.00	741,192.00
35130	Эм боох материал	00.00	741,192.00
354	Хангамжийн материал	79,221,500.50	81,364,963.00
35420	Аж ахуйн материал	59,877,270.00	61,593,470.00
35460	Хүнсний материал	4,381,870.50	3,078,820.50
35470	Бусад хангамжийн материал	14,962,360.00	16,692,672.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,309,916,437.50</u></b>	<b><u>1,312,550,445.41</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,309,916,437.50	1,312,550,445.41
392	Биет хөрөнгө	1,187,156,437.50	1,189,790,445.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,192,180,298.00	1,192,494,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,147,351.64	-72,851,236.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,382,802.30	53,609,703.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,760,481.19	-36,203,958.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,694,673.69	81,780,655.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,247,683.66	-32,099,698.03
39217	Ном	3,054,180.00	3,060,180.00
393	Биет бус хөрөнгө	122,760,000.00	122,760,000.00
39301	Программ хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	122,760,000.00	122,760,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,403,137,938.00</u></b>	<b><u>1,403,858,163.41</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>577,919.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>577,919.00</b>
413	Өглөг	00.00	577,919.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	577,919.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,403,137,938.00</u></b>	<b><u>1,403,280,244.41</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,403,137,938.00	1,403,280,244.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	748,362,587.00	625,602,587.00

51101	Өмч: - төрийн	748,362,587.00	625,602,587.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>559,479,408.30</b>	<b>683,400,880.71</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	559,479,408.30	560,498,574.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	122,902,306.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	95,295,942.70	94,276,776.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,403,137,938.00</b>	<b>1,403,858,163.41</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,138,546,403.80</b>	<b>900,005,332.92</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,056,799,224.80</b>	<b>167,034,832.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>520,997,324.80</b>	<b>167,034,832.92</b>
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		163,669,128.42
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,365,704.5
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>535,801,900.00</b>	<b>00.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	535,801,900.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>81,747,179.00</b>	<b>732,970,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>00.00</b>	<b>610,868,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	610,868,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>230,000.00</b>	<b>00.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>81,517,179.00</b>	<b>122,102,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,517,179.00	122,102,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>601,089,365.88</b>	<b>776,805,003.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>601,089,365.88</b>	<b>776,805,003.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>592,425,352.88</b>	<b>759,878,243.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>393,707,359.00</b>	<b>452,495,428.00</b>
210101	Үндсэн цалин	312,745,659.00	321,179,340.00
210102	Нэмэгдэл	40,094,380.00	103,910,582.00
210104	Урамшуулал	40,867,320.00	27,405,506.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,055,263.00</b>	<b>55,770,533.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,324,563.00	38,639,045.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,932,600.00	4,472,268.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,146,200.00	3,572,025.00
210204	Ажилгүйдлийн даатгал	786,600.00	826,108.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,865,300.00	8,261,087.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>81,091,379.00</b>	<b>82,345,480.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,593,447.00	4,798,773.00
210302	Түлш, халаалт	67,888,480.00	67,888,480.00
210303	Цэвэр, бохир ус	10,609,452.00	9,658,227.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,365,538.00</b>	<b>30,486,350.00</b>
210401	Бичиг хэрэг	325,100.00	98,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,850,000.00	1,898,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,101,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,047,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,609,000.00	4,516,950.00
210408	Бараа материал акталсны зардал	6,433,138.00	23,973,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>21,726,762.00</b>	<b>84,033,155.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,800.00	161,400.00
210502	Хоол, хүнс	21,589,962.00	83,871,755.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>250,800.00</b>	<b>3,317,300.00</b>
210604	Урсгал засвар	250,800.00	3,317,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>260,700.00</b>	<b>580,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	260,700.00	580,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,038,000.00</b>	<b>1,238,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	738,000.00	1,238,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,929,551.88</b>	<b>49,611,697.79</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,010,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,781,372.80	3,623,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,148,179.08	37,977,097.79
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,664,013.00</b>	<b>16,926,760.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>800,000.00</b>	<b>16,416,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	16,416,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>510,060.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	510,060.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,864,013.00</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,864,013.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>537,457,037.92</b>	<b>123,200,329.13</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>500,071.03</b>	<b>298,022.72</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	500,071.03	298,022.72
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-500,071.03</b>	<b>-298,022.72</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>536,956,966.89</b>	<b>122,902,306.41</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>617,549,079.00</b>	<b>732,970,500.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	535,801,900.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	535,801,900.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	535,801,900.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>81,747,179.00</b>	<b>732,970,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	610,868,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	610,868,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	81,517,179.00	122,102,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,517,179.00	122,102,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>617,549,079.00</b>	<b>723,768,937.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>617,549,079.00</b>	<b>723,768,937.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,885,066.00	706,842,177.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,266,000.00	451,917,509.00
210101	Үндсэн цалин	312,304,300.00	320,601,421.00
210102	Нэмэгдэл	40,094,380.00	103,910,582.00
210104	Урамшуулал	40,867,320.00	27,405,506.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,265,047.00	55,770,533.00
210201	Тэтгэврийн даатгал	36,534,347.00	38,639,045.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,932,600.00	4,472,268.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,146,200.00	3,572,025.00
210204	Ажилгүйдлийн даатгал	786,600.00	826,108.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,865,300.00	8,261,087.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,091,379.00	82,345,480.00
210301	Гэрэл, цахилгаан	2,593,447.00	4,798,773.00
210302	Түлш, халаалт	67,888,480.00	67,888,480.00
210303	Цэвэр, бохир ус	10,609,452.00	9,658,227.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,737,400.00	00.00
210401	Бичиг хэрэг	325,100.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,850,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,101,300.00	00.00
210404	Ном, хэвлэл	284,100.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,300,000.00	00.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,876,900.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,710,440.00</b>	<b>82,526,605.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,800.00	00.00
210502	Хоол, хүнс	23,601,640.00	82,526,605.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	972,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,425,800.00</b>	<b>3,317,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	425,800.00	3,317,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>260,700.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	260,700.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,038,000.00</b>	<b>1,238,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	738,000.00	1,238,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,090,300.00</b>	<b>29,726,450.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	26,726,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,090,300.00	3,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,664,013.00</b>	<b>16,926,760.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>800,000.00</b>	<b>16,416,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	16,416,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>510,060.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	510,060.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,864,013.00</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,864,013.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>9,201,563.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>9,201,563.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>9,201,563.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	748,362,587.00	95,295,942.70	559,479,408.30	1,403,137,938.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	1,019,166.00	1,019,166.00

	Бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	748,362,587.00	95,295,942.70	560,498,574.30	1,404,157,104.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,019,166.00	00.00	-1,019,166.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	122,760,000.00	00.00	00.00	-122,760,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	122,902,306.41	122,902,306.41
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	625,602,587.00	94,276,776.69	683,400,880.71	1,403,280,244.41

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	610,868,300.00	601,666,737.00	9,201,563.00	98%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610,868,300.00	601,666,737.00	9,201,563.00	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,451,600.00	585,250,037.00	9,201,563.00	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	421,008,600.00	419,839,704.00	1,168,896.00	100%
210101	Үндсэн цалин	329,634,800.00	294,277,747.00	35,357,053.00	89%
210102	Нэмэгдэл	78,164,000.00	100,259,444.00	-22,095,444.00	128%
210104	Урамшуулал	13,209,800.00	25,302,513.00	-12,092,713.00	192%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,626,100.00	51,918,978.00	707,122.00	99%
210201	Тэтгэврийн даатгал	35,785,900.00	35,919,223.00	-133,323.00	100%
210202	Тэтгэмжийн даатгал	4,210,000.00	4,152,289.00	57,711.00	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,368,000.00	3,316,042.00	51,958.00	98%
210204	Ажилгүйдлийн даатгал	842,000.00	775,584.00	66,416.00	92%
210205	Эрүүл мэндийн даатгал	8,420,200.00	7,755,840.00	664,360.00	92%
2105	Нормативт зардал	89,811,700.00	82,526,605.00	7,285,095.00	92%

210502	Хоол, хүнс	89,811,700.00	82,526,605.00	7,285,095.00	92%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,258,000.00	1,238,300.00	19,700.00	98%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	1,238,300.00	19,700.00	98%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,747,200.00	29,726,450.00	20,750.00	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,747,200.00	26,726,450.00	20,750.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	3,000,000.00	0.00	100%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,416,700.00	16,416,700.00	0.00	100%
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,416,700.00	16,416,700.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,416,700.00	16,416,700.00	0.00	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	610,868,200.00	610,868,300.00	-100.00	100%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	610,868,200.00	610,868,300.00	-100.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	610,868,200.00	610,868,300.00		
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0	9,201,563.00		
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	32	32		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	21	21		
136	Үйлчлэх ажилтан	10	10		
137	Гэрээт ажилтан	10	10		

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутаг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	122,102,200.00	121,592,140.00	510,060.00	100%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	122,102,200.00	121,592,140.00	510,060.00	100%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	122,102,200.00	121,592,140.00	510,060.00	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,388,000.00	32,077,805.00	310,195.00	99%

210101	Үндсэн цалин	32,388,000.00	26,323,674.00	6,064,326.00	81%
210102	Нэмэгдэл	0	3,651,138.00	-3,651,138.00	
210104	Урамшуулал	0	2,102,993.00	-2,102,993.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,048,400.00</b>	<b>3,851,555.00</b>	196,845.00	95%
210201	Тэтгэврийн даатгал	2,752,900.00	2,719,822.00	33,078.00	99%
210202	Тэтгэмжийн даатгал	323,900.00	319,979.00	3,921.00	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	259,100.00	255,983.00	3,117.00	99%
210204	Ажилгүйдлийн даатгал	64,800.00	50,524.00	14,276.00	78%
210205	Эрүүл мэндийн даатгал	647,700.00	505,247.00	142,453.00	78%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>82,348,500.00</b>	<b>82,345,480.00</b>	3,020.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	5,613,000.00	4,798,773.00	814,227.00	85%
210302	Түлш, халаалт	67,891,500.00	67,888,480.00	3,020.00	100%
210303	Цэвэр, бохир ус	8,844,000.00	9,658,227.00	-814,227.00	109%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,317,300.00</b>	<b>3,317,300.00</b>	0.00	100%
210604	Урсгал засвар	3,317,300.00	3,317,300.00	0.00	100%
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>122,102,200.00</b>	<b>121,592,140.00</b>	510,060.00	100%
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>122,102,200.00</b>	<b>121,592,140.00</b>	510,060.00	100%
320001	Орон нутгийн төсвөөс	122,102,200.00	121,592,140.00	510,060.00	100%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын 7-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тайлант онд тус цэцэрлэг нь "Хүүхдийн хүсэл сонирхол, хэрэгцээнд тулгуурласан хүүхэд өөрөө бүтээгч байх боломжит сургалтын орчныг бүрдүүлж, хүүхэд бүрийн авьяас чадварыг хөгжүүлэх" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.

- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 720.2 мянган өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	9,201.5	9,201.5
Авлага	14,000.0	-	-14,000.0
Бараа материал	79,221.5	82,106.1	2,884.6
Үндсэн хөрөнгө	1,309,916.4	1,312,550.4	2,634.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,403,137.9</b>	<b>1,403,858.1</b>	<b>720.2</b>
Өр төлбөр	0	577.9	577.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,403,137.9	1,403,280.2	142.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,403,137.9</b>	<b>1,403,858.1</b>	<b>720.2</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,201.5 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэлгүй болж 14,000.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой 2021 оны 12-р сарын 31-нд хөрөнгө хүлээн зөвшөөрөлтийн шалгуур бүрэн хангаагүй байсан учир шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн. Харин 2022 онд хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуурт бүрэн нийцсэн учир авлагыг бууруулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82,106.1 мянган төгрөг болж 2,884.6 мянган төгрөгөөр өсжээ. Энэ нь худалдан авсан болон шилжүүлэн авсан бараа материалын зарцуулагдаагүй үлдэгдэл байна. Худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,312,550.4 мянган төгрөг болж 2,634.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь бараа материалын дансанд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг ангилал өөрчлөн бүртгэсэн болон үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөр данс нь 577.9 мянган төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгал болон татварын өглөг үүссэнтэй холбоотой байна. Энэ онд харилцагч байгууллагуудтай холбоотой өр төлбөр нь тооцооны үлдэгдлээр баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,403,280.2 мянган төгрөг болж 142.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 647,100.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 85,870.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 732,970.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байдлаас шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 610,868.3 мянга, орон нутгийн төсвөөс 122,102.2 мянга, нийт 732,970.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 610,868.3 мянга, орон нутгийн төсвөөс 122,102.2 мянга, нийт 732,970.5 мянган төгрөгийн төсвийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 723,258.9 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 9,711.6 мянган төгрөгөөр хэмнэж ажилласантай холбоотой байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	89,811.7	82,526.6	7,285.1	91.8%
2	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,727.4	2,727.4		100%
3	Боловсролын байгууллагын багш,	1,700.0	1,700.0		100%
4	Эрүүл мэндийг дэмжих	1,700.0	1,700.0		100%
5	Боловсролын стандарт, сургалтын орчин	413,618.4	412,176.4	1,442.0	99.6%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	101,310.8	100,836.4	474.4	99.5%
7	Нийтлэг үйлчилгээ	36,436.4	35,929.3	507.1	100%
8	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	85,665.8	85,662.8	3.0	100%
		732,970.5	723,258.9	9711.6	98.6%

Цэцэрлэгийн хүүхдийн хоол хөтөлбөр, арга хэмжээний хувьд өвлийн улиралд ханиад томуу дэгдэлттэй холбоотой мөн цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн өвлийн амралтын хугацаа эхлэх үед хүүхдийн ирцийн хувь төлөвлөсөн хэмжээнээс эрс буурсантай холбоотойгоор 7,285.1 мянган төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн

байна. Мөн боловсролын стандарт сургалтын орчин, сургалтын хэвийн үйл ажиллагааны зардлаас 1,442.4 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдэл 474.4 мянга, нийтлэг үйлчилгээний зардал 507.1 мянга, Төрийн өмчийн барилгын тогтмол зардал 3.0 мянга, нийт 9,711.6 мянган төгрөгийн хэмнэлт гарснаас орон нутгийн төсвийн санхүүжилтийн 510.1 мянган төгрөгийг төвлөрүүлж 9,211.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ариун төгс оршихуй Аудит” ХХК-ийн аудитор С.Эрдэнэчимэг гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ариун төгс оршихуй аудит” ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан тул материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 621,467.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,214.6 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 776,805.0 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 7,768.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,214.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 142, хугацаа хоцроосон 7, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Улаангом сумын 7-р Цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогыг нарийвчлан тусгагдаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа нь харилцан адилгүй ялгаатай байна.

Үүнтэй холбоотой байгууллагын одоогийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай байна.

Тус цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс тайлант хугацаанд 197,994.1 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 149,571.5 мянган төгрөгийн худалдан авалт нь И-баримтаар баталгаажаагүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаангом сумын 7-р цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ”

ХХК-ийн АУДИТОРС

/С.ЭРДЭНЭЧИМЭГ/

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

